

Сонин бичиг

Глобинтернэшнл ТББ



№-1 12 сар, 2005 он

www.globeinter.org.mn

ННФорум, Будапешт дэх ННХ-ийн санхүүжилтээр 2005 оны 10-р сараас эхлэн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” нэг жилийн хугацаатай хэрэгжих төслийн хүрээнд “Глоб Интернэшнл” ТББ хоёр сар тутамд энэхүү **сонин бичгийг** эрхлэн гаргана.

Бэлтгэсэн:

- Г.Даваахүү
- Ч.Ерөөлсүрэн
- Д.Мөнхбүрэн
- Х.Наранжаргал
- Г.Нарангарав
- Х.Цэвлээ

Хянасан:

Х.Наранжаргал

Агуулга

- Төслийн танилцуулга
- Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж
- Нэгдүгээр нүүр**

-Өвөөгийн жор

Хоёрдугаар нүүр

- Өвөөгийн жор /үргэлжлэл/
-Сэтгүүлч таны мэдлэгийн санд “Глоб интернэшнл”ТББ-ын номын санд байгаа ном
Ч.Базар
“Хэрхэн эрэн сурвалжлага хийх вэ”
“Мэдээллийн эрх чөлөө”

Гуравдугаар нүүр

- Сэтгүүлч та тэтгэвэр авах уу?
“Олон нийтийн мэдэх эрх мэдээллийн эрх чөлөө” гарын авлага
“Сэтгүүл ба хууль”5 цуврал товхимол
“Эмэгтэй сэтгүүлчид, эмэгтэйчүүд хүүхдийн эрхийн тухай” гарын авлага

Дөрөвдүгээр нүүр

- Нэр төр, гүтгэлэг ба хэвлэл мэдээлэл
Тавдугаар нүүр
-Эх сурвалжаа хамгаалах нь /номын хэсгээс/
“Авилгал:Мөнхийн үзэгдэл биш”ном
“Олон нийтийн радио телевиз”ном
Зургаадугаар нүүр

-Ажил мэргэжлийнхээ төлөө амь үрэгдсэн сэтгүүлчид /номын орчуулга/

Долдугаар нүүр

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд 2005 оны 11 дүгээр сарын 16-нд “Глоб Интернэшнл” ТББ-ын байранд сэтгүүлчдийн уулзалтыг зохион байгуулав. Энэ уулзалтад өдөр тутмын болон долоон хоног тутмын сонин сэтгүүлч, РТВ-ийн дээд сургуулийн багш, Монголын үндэсний Радиогийн сурвалжлагч зэрэг нийт найман хүн оролцож, санал бодлоо чөлөөтэй солилцов.

Уулзалтын эцэст сэтгүүлчдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сэтгүүлчдийн мэдээллийн эрх сурвалжаа хамгаалах эрхийг баталгаажуулах мөн хуульч, шүүгч, прокурорруудад сэтгүүл зүйн талаар ойлголт өгөх, сэтгүүлчдийг яллах бус өмгөөлөх, олон улсын практик хэм хэмжээг хэрэглэх сургалтуудыг зохион байгуулах зэрэг санал гаргасан байна.

Хуульчид сэтгүүлчийн эрхийн зөрчлийг хэрхэн ойлгож байгаа талаар санал солилцох зорилгоор 2005 оны 11 дүгээр сарын 23-нд “Глоб интернэшнл”ТББ-ын байранд хуульчдын уулзалтыг зохион байгуулсан. Энэ уулзалтад нийт таван хуульч оролцсон байна.

Уулзалтын үеэр сэтгүүлчийн ямар эрх хуулиар хамгаалагдсан, ямар эрхийг хуулиар огт хамгаалаагүй байдаг зэргийг ялгаж салгаж өгөх. Шүүх, цагдаагийн байгууллагад сэтгүүл зүйн сургалт явуулахыг хуульч Д.Зүмбэрэлхам зөвлөжээ.

Мэдээлэл нотлох баримттай бол сэтгүүлч шүүх дээр өөрийгөө хамгаалах боломжтой. Гэтэл өнөөгийн байдлаар сэтгүүлчийн хангалттай нотлох баримтгүй бичсэн нийтлэлээс зарга үүссэн тохиолдолд сэтгүүлчийг өмгөөлөхдөө нэхэмжлэгчид чухам ямар бодитой хохирол учирсныг тодруулахыг шаарддаг гэж хуульч Болорчулуун ярьсан байна.

IFEX-ийн мэдээ

Сонгуулийн үеэр олон сэтгүүлчдэд халджээ



Asmaa Ali Hraiz after the assault.

Улсыг аюулаас хамгаалах албаны ажилтнууд Египетийн сөрөг хүчний долоо хоног тутмын “Аль-Карам” сонин сэтгүүлч Фстаа Али Храизыг Шубра аль-Кхейм хотын сонгуулийн төвөөс хулгайлжээ. Түүнийг хулгайлсан хүмүүс гар утас, камер, алтан зүүлт зэргийг нь авч, “хүчирхийлнэ” хэмээн заналхийлсэн байна. Сэтгүүлч эмэгтэйн хавирга хугарч, баруун гар нь хүнд гэмтэснээс гадна нуруу нь хөх няц болсон байжээ...

ДОХ-той тэмцэгч идэвхтнүүдийг илүү найдвартай хамгаалах шаардлагатай

Хятадад л гэхэд 1990-ээд онд улсын хэмжээнд өрнөсөн донорын хөдөлгөөний үеэр ядуу зүдүү сая орчим хүн ДОХ-ын вирусээр халдварласан хэрэгт төр буруутай болохыг олон нийтэд мэдээлэхийг оролдсон Ван Йанхай тэргүүтэй идэвхтнүүдийг шоронд хорьсон байна...



Дэлгэрэнгүй мэдээллийг “Глоб интернэшнл”ТББ-ын цахим хуудаснаас буюу дараах хаягаар авна уу: <http://www.globeinter.org.mn>

Төслийн танилцуулга



“Глоб Интернэшнл” ТББ нь ННФорум, Будапешт дэх ННХ-ийн санхүүжилтээр 2005 оны 10-р сараас эхлэн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төсөл хэрэгжүүлж эхлээд байна.

Төслийн хүрээнд Москва хотноо төвтэй **Онцгой нөхцөл дэх сэтгүүлчдийн төв болон Олон Улсын чөлөөт Илэрхийллийн сүлжээтэй IFEX-тай** хамтран ажиллах юм.

Ардчилалыг хөгжүүлэх үйл явцад тэргүүлэх үүрэгтэй оролцох ёстой Монголын хэвлэл мэдээлэл бүрэн эрх чөлөөтэй байх нөхцлийг хангах үүднээс хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг хамгаалах аян өрнүүлэх, **үзэл бодлын эрх чөлөөний зөрчилд мониторинг хийх** боломжийг хөгжүүлэхэд энэхүү төслийн гол зорилго оршино.

Монгол дахь үзэл бодлын эрх чөлөөний бодит байдлын талаархи мэдээ мэдээлэл улс орны дотор болон хилийн чанадад хомс байгаа юм. Энэ талаар анхаарал тавьж ажилладаг байгууллага байхгүй, техникийн бааз суурь бүрдээгүй, үзэл бодлын эрх чөлөөний зөрчлийн талаар олон улсын стандарт шаардлага хангах тайлан мэдээ бэлтгэх боломжгүй зэргээс уг байдал үүсээд байгаа билээ. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дэлхий дахинаа хэвлэлийн эрх чөлөөний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагатай хамтран ажиллах боломж бүрдэх юм.

Төслийн явцад үзэл бодлын эрх чөлөөний зөрчилд мониторинг хийх, үндэсний хэмжээнд мониторингийн сүлжээ байгуулах, сургалт явуулах ба сэтгүүлчдэд боловсрол олгох, хууль эрх зүйн тусалцаа үзүүлэх болно. Мөн үндэсний болон олон улсын хэмжээнд үзэл бодлын эрх чөлөөг өмгөөлөх, Монгол дахь үзэл бодлын эрх чөлөөний талаархи мэдээ мэдээллийг үндэсний болон олон улсын хэмжээнд түгээн сурталчлах явдлыг нэмэгдүүлэх, “Глоб Интернэшнл” ТББ-г IFEX-ийн гишүүнд элсүүлэх улмаар Глоб Интернэшнл ТББ-г Үндэсний хэмжээний Сэрэмжлүүлэх үйл ажиллагаа хангагч байгууллага болгох зорилт хэрэгжинэ.

**Сэтгүүлч таны хэрэгцээнд:
/тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж/**

Миченэр-Диконы тэтгэлэг- Сэтгүүл зүй:
Дөрвөн сарын сургалтанд зориулагддаг 20.000 ам долларын тэтгэлэг юм. Өргөдөл гаргагч нь туршлагатай сэтгүүлч байх бөгөөд сонирхож байгаа хөтөлбөр нь нийгэмд нөлөө үзүүлэхүйц томоохон асуудал байвал зохино.

Харилцах хаяг: info@michenerawards.ca нэмэлт мэдээлэл авах цахим хуудас: <http://www.comminit.com/Fellowships/sld-1511.html>

Кино болон баримтат бүтээлийн тэтгэлэг:
АНУ-ын Хүмүүнлэгийн Ухааны сургуулиас кино болон сонирхолтой бичлэгийг дэмжих 10.000 ам.доллар хүртэлх хэмжээний тэтгэлэг.
Өргөдлийн маягтыг авах цахим хуудас: <http://www.theihs.org/tab1/mfa.html>

Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн Сэтгүүлчийн дадлага:
Өдөр тутмын сонинд өгүүлэл бичих, мэдээ бэлтгэх, тойм коментари хийхэд туслах, эрэн сурвалжлах нийтлэлийн ажилд оролцох зэрэг цалинтай дадлага хийлгэдэг.
Өргөдлийн маягтыг <http://www.theihs.org/tab1/j.html> цахим хуудаснаас авна уу.

Үзэл бодлоо илэрхийлэх сүлжээ буюу /IFEX/ гэж юу вэ?

IFEX нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд ажиглалт хийж, мэдээллээ дэлхий даяар хувь хүмүүс, байгууллагуудад түгээн тараадаг 64 байгууллагын бодит сүлжээ юм.

IFEX нь 1992 онд дэлхийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний чиглэлээр ажилладаг тэргүүлэх байгууллагууд Канадын Монреал хотноо чуулж, цаашид хамтын зорилгодоо хэрхэн хүрэх тухай хэлэлцсэний үр дүнд үүсэн байгуулагдсан билээ. Үүний мөн чанар нь цагдан хяналт тавих, халдлагад өртөх, амь насаа алдах зэргээр зөрчигдөж буй хүний эрхийн суурь эрхийн нэг болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөө зориглон зүтгэх тийм байгууллагуудыг нэгтгэсэнд оршино. IFEX бол нийтлэг зорилгынхоо төлөө сэтгэл санаагаа зориулсан, хоорондоо ихээхэн ялгаатай олон улсын байгууллага, хүмүүсийг хамтын хүчийг эгнээндээ нэгтгэдэг. Сүүлийн жилүүдэд хөгжиж буй орны байгууллагууд IFEX-д гишүүнээр элсэж, шинэ төлөв хандлага, шинэ эрч хүч нэмж байна.

Мониторинг гэж юу вэ?

Monitoring хэмээн англи үг нь “ажиглах, ажиглан харах үйл явц, бүртгэн тэмдэглэх” гэсэн утгатай юм.

Мониторингийн улс төрийн нөхцөл байдал, технологийн үйл явц, нийгмийн амьдралын хүрээ, эсвэл үйл ажиллагаа, тодорхой хугацааны онцгой шинж бүхий зүй тогтлын тухай олж мэдэхийг хүссэн хүмүүс, байгууллага гол төлөв хийж гүйцэтгэдэг.

Мониторинг бол хүний эрхийн аливаа байгууллагын үйл ажиллагааны чухал хэсэг юм. Ямарваа нэг салбарт хүний эрх аль хэр байнга зөрчигдөж буйг мэдэхийн тулд хэдэн сар, эсвэл бүр хэдэн жилийн турш ажиглалт хийх шаардлагатай байдаг. Зүй тогтлыг илрүүлсний эцэст л тэдгээрт дүн шинжилгээ хийж болно. Мониторинг хийх зарчим нь хүний эрхийг хамгаалагч, цаг уурын шинжээч, улс төр судлаач, анагаах ухааны ажилтнуудын хувьд адилхан байдаг.

Ашигласан материал:

Үзэл бодлоо илэрхийлэх олон улсын сүлжээ/IFEX/
Үйлдэлд дуудасан шуурхай мэдээ гарын авлага
Эрхээ хэрхэн хамгаалах вэ?

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эрхийн зөрчилд мониторинг хийх нь гарын авлага

SAIS-Новартис интернэшл сэтгүүл зүйн шагналын хөтөлбөр- Сэтгүүл зүй: Жон Хоркинсийн сургуулиас жилийн 15 мянган долларын мөнгөн шагнал, Вашингтонд ирж очих зардлын хамт шилдэг сэтгүүлчид гардуулдаг. Дэлхийн өнцөг булан бүрээс сэтгүүлчид уг шагналд тодорхойлох маягтын бүтээлээ ирүүлдэг. Харилцах хаяг: Intl.prize@jhu.edu, нэмэлт мэдээлэл авах цахим хуудас: <http://www.comminit.com/awards/sld-3139.html>

ЮНЕСКО /Гуллэрмо Каногийн шагнал-Хэвлэлийн эрх чөлөө: Дэлхийн өнцөг булан бүрт хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, тогтоох, ялангуяа энэ явцад эрсдэлд орж байсан шилдэг хувь хүн, байгууллагыг алдаршуулах зорилгоор жил бүр 25 мянган ам.долларын шагнал олгодог. Харилцах хаяг: s.coudray@unesco.org нэмэлт мэдээлэл авах цахим хуудас: <http://www.comminit.com/awards/sld-2200.html>

Глобал 500 шагнал- Байгаль орчны сэдвээрх залуусын сэтгүүл зүй: 19 хүртэлх насны залуусын бичсэн мэдээ, нийтлэлүүдийг шалгаруулан дэлхий нийтэд мэдээлнэ. Бичлэгийн сэдэв нь дэлхий ертөнц, түүн дээрх амьтдын сайн сайхны тухай байна. Нийтлэлийг сар бүрийн нэгэнд ирүүлсэн байвал зохино. Харилцах хаяг: news@ens-news.com, нэмэлт мэдээлэл авах цахим хуудас: <http://www.comminit.com/awards/sld-2599.html>.

Далайд дусал нэмэр



Өвөөгийн жор

АМЪДРАЛ “БАГШ”-ИЙН АНХНЫ ХИЧЭЭЛ

Хүмүүн хорвоогийн явдал тоолж үл барам олон өнгөтэй. Тэдгээрт хууртаж хаширахыг амьдралын их сургууль гэж гоё сайхнаар нэрлэнэ. Зарим нь “Үхэхээсээ бусдыг үзлээ” хэмээн чээж дэлдэж сайрхана. Чухамдаа бол амьдралд нухлуулж алдаж гэнэдэж явсныгаа магтаж байгаа

нь тэр. Хашир хүн гэж хаширсан хүнийг хэлнэ.

Залуу сэтгүүлч албан томилолт өвөрлөж анхны үүрэг гүйцэтгэх тэр торгон агшнаас л амьдрал хэмээх “Их багш” хичээл зааж эхэлнэ. Амьдрал “Их багш”-ийн зан нь шударга, дүн нь хатуу, арга нь өвөрмөц. Өө. Тэр шинэ эрдэм заахын оронд хуучин ухаан заана. Ном уншуулахын оронд зовлон уншуулна. Ажил авангуут л зовлон амсуулж эхэлнэ. Эхний хичээл нь хууртахын зовлон байх болно. Хууртахыг хүний үгэнд хууртах, амьдралын үнэнд хууртах гэхчлэн хувааж бас болно.

1. Үгэнд хууртахын зовлон

Сэтгүүлчийн багаж зэвсэг нь үг. Багаж зэвсэг нь барьж байгаа эзнээ барагтай бол хуурдаггүй. Харин үгэн зэвсэг хуурдаг. Үг бол үе үе хуурамч зан гаргадаг нилээн “Тогтворгүй этгээд” шүү дээ. Үг гадаад өнгө, хэлбэр дүрсээ хувиргахгүй мөртлөө “Сэтгэлээ” хувиргах нь олонтааг. Сэтгүүлч хүн болчимгүй найздаа хууртсан байвал нэгэн биеэрээ хохирно. Харин болчимгүй үгэнд хууртсан байвал нийт түмнээрээ хохирно. Нийгмийн хариуцлагатай сэтгүүл зүйн нэг үндсэн шаардлага нь энэ юм.

Үг өөрөөсөө урвасан мэт огт өөр утга илэрхийлэх нь бий. Зүйрлэн бодвол үг заримдаа зөөлөн хурын үүл шиг намираа бороо асгаруулж ч болно, бас цас мөндөр буулгаж зуд турхан авчирч ч болно.

Хамгийн ярвигтай нь үг бүхэн үнэнийг илэрхийлж өгдөггүй юм. Үнэн үгний зэрэгцээ худал үг гэж байна. Гүтгэгдсэн хүн “Би хулгайлаагүй” гэсэн бол тэр нь үнэн үг байдаг. Гэтэл жинхэнэ хулгайчийнх нь амнаас гардаг “Би хулгайлаагүй” гэдэг үг нь би хулгай хийсэн гэсэн үг болж таардаг. Хоёулаа адилхан “Би хулгайлаагүй” гэсэн байтал нэг нь үнэн, нөгөө нь худал үг болж байна.

Сурвалжлагчийн заавал сурч авсан байх ёстой мөртлөө танхимд бараг заалгадаггүй, харин ажил дээр гарсныхаа дараа алдаж гэнэдэж яваад амьдралаас сурдаг эрдэм бол хүнээр хэлэх гээгүй үгийг нь хэлүүлж чаддаг болох ур чадвар юм. Тэр нь хулгай хийсэн этгээд хулгай хийгээгүй гэж мэлзээд байвал түүний худал хэлснийг нотолж хүлээлгэх ур чадвар олж авна гэсэн утгатай юм. Битүү танадах, баримтаар бүслэх, нүүр тулан илэн далангүй харилцан ярилцах зэрэг олон хувилбарын арга байж болдог. Тэр дундаас илүү үр дүнтэй нэг арга нь тухайн хүний сэтгэл зүйн онцлог дээр тоглож “Ам алдуулах” урлаг юм. Түүнийг эрэн сурвалжлагын нэг том түлхүүр гэж болно.

1940-өөд оны үед юм байж. Нутгийн баян эр тэнзэн ташуураа хулгайд алдчихжээ. Алдсан хүн арван тамтай гэж нэг танил нөхрөө авчихлаа гэж хардаад тэднийд авдар дотроос нь цухийж байсан гэнэ лээ гэж өргөдөлдөө бичээд шүүхэд өгчээ. Байцаажээ. Улайдаггүй гэнэ. Байцаагч нь хулгайд хардагдсан нөхрийг таньдаг нэг нутгийн байхгүй. Маргааш өглөө ирээрэй. Чи тэр ташуурыг хуульчлан хийж юм байна. Харин маргааш хоёулаа чиний зөв үгний үсгээ зурж бичиг баримтаа цэгцлэх болно. Өө. Тэр үгээрэй гээд явуулж.

Өглөө болж. Мань эр хүрээд ирж. Байцаагч уулзаад мэнд мэдсэний дараа -Үгүй хө чамд л гэж хэлэхэд манай сумын баячуудад мөс жудаг гэж алга болсон байна шүү. Тэр тусмаа энэ ягаан өвгөний удмынхан бүр ч хэрэггүй улс байна шүү. Алд ташуур гээд байгаа юм. Ял хүндрүүлэх гэхдээ худлаа ярьж байгаа юм. Алд ташуур авдранд багтана гэж хаанаас байхав дээ. Иймхэн л юм байсан байлгүй гээд тохойгоор жишин заахад цаадах нь “Тийм тийм” гэж толгой тохиж ам алдаад түүнээсээ бантаж ороогдоод хулгай хийснээ хүлээж ташуурыг нь гаргаж өгсөн гэдэг юм.

Чингэхлээр харилцагчийнхаа хэлэн дээр нь ил байгаа хуурамч үгийг сонсохдоо сэтгэлд нь оршин байгаа хэлээгүй далд үнэн үгийг нь сонсох ур чадвартай болох хэрэгтэй. Үүнийг сэтгэлийн нүдтэй болох гэж нэрлэх нь бий. Сэтгэлдээ нүдгүй бол үнэнийг олж мэдээлэх тухай бодохын ч хэрэг байхгүй.

Үнэн худлаа үгнээс гадна өгөө үг, далд үг гэж байдаг. Байгаагаараа байж байгаа үг гэж байхаас гадна байхгүй атлаа байгаа үг гэж байна. Үүнийг өгөөдөж дэгээдэж гаргаж ирнэ. Хүний хэлээгүй үгийг амьдралын баримт дүрслэлээр олж хэлдэг хүн ихэвчлэн уран бүтээлч болдог. Жишээ нь хавханд орсон зээр үг хэлэхгүй боловч хэлбэл ямар үг хэлэх хэлсныг нь хуульч Сандаг олж хэлсэн байдаг. Энэчлэн зохиолч сэтгүүлчдийн эрэл хайгуул гэдэг нь чухамдаа амьдралын хэлээд байгаа мөртлөө үгээр илэрхийлж хэлэхгүй байгаа далд үгийг олж хэлэхийн төлөө мэрийлт байх нь олонтаа.

Манайд сүүлийн үед ховордож байгаа бөгөөд уншигч түмний хүсэн хүлээж байдаг үг бол өгөө үг юм. Одоогоос 80-аад жилийн тэртээ Монголын хэвлэлд гарсан нэг өгөө өгүүлийг энд ишлэн сонирхуулья.

Гарчиг нь ЛАЛАР. Нэгэн хүн... гэнэт морины ширүүн төвөргөөн сонсдоход эргэж харваас хэнгэрэг болсон гэдэстэй, хэдрэг болсон нуруутай, барьж мордох мундаагүй батгана үргээх сүүлгүй, дохиур болсон толгойтой, домбо болсон хөлтэй, зандан цайвар морийг унасан нэгэн яйжгар өвгөн ирэв. Ажиглаваас малгайгүй маахууртай, дээлгүй хүрэмтэй, өмдгүй тэлээтэй, гуталгүй оймстой, эмээлгүй янхирцагтай, ташуургүй бэрээтэй, хазааргүй ногттой юм гэнэ. Тэр өвгөнөөс Таны нэр хэн бэ? гэтэл би газар бүр хэсч, сонин бүрийг сонсч, учир бүрийг мэдэж явдаг лалар гэгч байна” гэжээ. Лалар гэдэг нь “Хамаагүй намбаагүй хүн” гэсэн утгаар хэрэглэдэг үг.

Энд юу нь үнэ цэнэтэй байнав гэвэл ажил амьдралдаа арчаагүй, хоосон сүржигнэдэг дуураймал хүнийг Монгол ахуйн онцлог буулган урнаар өгөөдөн дүрсэлсэн нь содон байна. Одоо ч өмдгүй мөртлөө ганган тэлээтэй явдаг гэмээр хэлбэр хөөцөлдсөн өнгө засагч долигонуур хүн олон байгаа шүү дээ. Түүнээс гадна эзнийхээ муугаас эцэж турсан морины гэдсийг хэнгэрэгтэй, нурууг хэдрэгтэй, толгойг дохиуртай, хөлний бэрэвхийг домботой зүйрлэсэн нь нүдэнд харагдуулж чадахаар дүрслэл болж чадсан байна.

2. Амьдралд хууртахын зовлон

Ухаарч ойлгоогүй боловч туулж гарахаас өөр аргагүй болсон ярвигтай зарим асуудал өнөөдөр манай төр засгийг төдийгүй нийт ард түмнийг түүний дотор залуу сэтгүүлчдийг мэдэхгүйн зовлонгоор зовоож байгааг нотлох гэсэн юм шиг дутуу зэрэмдэг хууль тогтоолын хажуугаар түүхий нийтлэлүүд ар араасаа цуварч байна.

“Хамгийн хэрэгтэй юмаа мэдэхгүй юм. Мэдэж байгаа нь ашиггүй юм” гэж алдарт зохиолч И.В.Гёте өөрийн нэгэн гол жүжгийн баатар Фаустаар хэлүүлсэн байдаг. Ийм зовлон эдүгээ зөвхөн залуу сэтгүүлчдийг төдийгүй хашир улс төрчидийг ч хууран мэхлэсээр байна. Сэтгүүл зүйн салбарт ойрхон бодож хагас дутуу сурвалжилсанд орвол огт хөндөхгүй байсан нь дээр байж дээ гэмээр түүхий шүүрхий нийтлэл олон гарч байгаа нь шинэдэхийн зовлон юм. Тиймээс А,Б хэмээх хоёр хүн хоорондоо ярилцсан зохиомжийн хэлбэр ашиглан залуу сэтгүүлчдэд хэзээний мэддэг юм шиг мөртлөө

жинхэнээр нь мэдэхгүй төөрөлдөж болох хоёрхон асуудлын гүн рүү өнгийх гэж оролдоод үзье.

А,Б хоёр татварын тухай ийн хүүрнэлджээ. -Татварын шинэтгэл хийнэ гэнээ. Манай УИХ-ынхан хуулийн төсөл боловсруулж хоорондоо ярилцаад л байгаа сурагтай байна. Гэхдээ тэр хуулийн тухайд биш, харин ард нийтээрээ мэдэж байгууштай татварын тухай ерөнхий асуудалд чиний анхаарлыг хандуулмаар байна. Татвар гэж юу вэ?

- Миний ойлгож байгаагаар татвар бол "Ертөнцийн гурван үнэн"-ий нэг. "Төрсний дараа үхэх үнэн. Төрсний дараа татвар төлөх үнэн. Тэр хоёртой тэнцэх нийтлэг үнэн байхгүй нь бас үнэн". Ингээд ертөнцийн гурван үнэн бүрдэж байгаа юм даа - Гадна хүн би итгэхгүй байна. Жишээ нь нярай балчир үрс, гуйлгачин ядуус татвар төлдөггүй биз дээ.

-Энэ чинь шал худлаа байхгүй юу. Өлбөрч байгаа хүн сүүлчийн амссан аяга хар цайнаасаа хүртэл төрдөө татвар төлөөд амьсгалаа хураадаг юм.

-Арай ойлгомжтой болгон ярьж болохгүй юу?

- Болно. Өөрөөр ярьж болно. Усгүй бол хүн ангаж үхнэ. Агааргүй бол бүтэж үхнэ. Татвар төлөхгүй бол өлбөрч үхнэ. Яагаад гэвэл талхны үнэд суусан татварыг нь орхиод талхыг нь аваад идчихэж болдоггүй.Тиймээс татвар төлдөггүй амьдралаар амьдрахыг хүсвэл ойн хүрэн баавгай, эсвэл чоно, үнэг мэтийн амьтан болохоос өөр замгүй.

-Наад зүйрлэл чинь амьдралд арай ойр дөт болж ирж байна. Тэгэхээр эндээс үүдэн нэг асуулт асууя.

- Намайг мэд суулгах нь уу?

—Үгүй ээ үгүй. Татварыг амьтай амьтан юм гэж бодвол амин сүнс нь юунд байж таарах вэ?

-Татварын алба эсвэл татвар төлөгчдөд сүнс нь оршдог байж таарна даа.

-Даанч биш байна.

-Тэгээд юу юм бэ?

- Аливаа юмны үнэ өртөгт татварын амин сүнс нь оршдог юм.

-Тэгвэл үнэ гэж юу юм?

-Товчоор ЗАР-АШ-ТАТ гэж хэлж болно.

-Ойлгомжгүй байна. Дэлгэрүүлж хэлээч

- Зардал, ашиг, татвар гэсэн үг. Үнэ гэсэн гуравхан үсэгтэй үгэнд чинь зардал, ашиг, татвар гэсэн гурван том амьдрал багтаж байдаг юм. Зардал нь үйлдвэрээ эргэн нөхөж, ашиг нь бизнесээ хөгжүүлж, татвар нь төр түмнийг тэжээж байдаг.

- Тэгвэл татварын шинэчлэл хийхэд эл бодит хуулийг чухам яаж ашиглах ёстой вэ?

-Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэд ийм гурван нэр төрлийн задаргаагаар шинжилгээ хийж худалдан авагч, хэрэглэгчдэд худалдсан бүх зүйлийн үнийг хураан авахдаа мөнгө хүлээн авсан тасалбар дээр үнийг нь энэ гурван бүтцээр нь бичдэг болох хэрэгтэй. Ингээд л гүйцэх нь тэр. Ийм практикт шилжүүлэх хууль л хэрэгтэй.

-Ер нь ашигтай, зүгээр арга байж мэдэх юм байна. Юуны өмнө мөнгө хураадаг технологийг л өөрчлөн сайжруулах хэрэгтэй юм байж.

-Яг миний ярьж байгаа шиг биш боловч татварыг аж ахуйн нэгжид биш бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэгжид нь оногдуулдаг тийм шудрага аргачлалыг өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулах цаг болоод байгааг хэлмээр байна.

- Өөр нэг асуудлаар чамтай ярилцъя. Тэтгэвэр гэж алт шиг биш бүр амь шиг чухал нандин үг монгол үгийн санд бий болжээ. Сайтар эргэцүүлэн ухаарвал энэ тэтгэвэр гэдэг чухам юу гэсэн үг вэ? Тэтгэж дэмжинэ гэсэн утгатай нь мэдээж боловч хэн нь хэнийгээ тэтгэхийн нэр вэ гэдэг нь сонин байна.

-Юу нь сонин гэж?

-Тэтгэвэр авагч өөрөө өөрийгөө тэтгэж байна уу эсвэл төр түүнийг тэтгэж байгаа юм уу?

-Тэр тухайд уу? Яг оносон утгаараа бол ажиллаж байсан хүн өөрөө өөрийгөө тэтгэж байгаа гэж болно. Тэрхүү тухайн нэр бүхий хүн албан ажил хийж байх хугацаандаа цалингийнхаа хэмжээнээс хамааруулан тусгай хууль дүрмийн дагуу төрийн дансанд нөөцөлж хураасан мөнгийг тэтгэврийн насанд хүрснийхээ дараа төрөөс тодорхой

зөвшөөрлөөр авч байгааг бид тэтгэвэр гэж нэрлэдэг юм. Төрд хүүгүй зээлдүүлсэн мөнгө гэсэн үг. Тэтгэврийг санхүүжүүлэх эх үүсвэр нь тухайн хүний хөдөлмөрийн орлогоос бүрдсэн нийгмийн даатгалын мөнгө, бас хөрөнгө оруулалт зэрэгт шингэсэн хөлс нь төлөгдөөгүй хөдөлмөрийн орлого байдаг гэж ойлгож болно. Тэгэхээр тэтгэвэр гэдэг чинь жинхэнэ утгаараа бол сулын цалин буюу бөгс мөнгө гэсэн үг. Манайхан тэтгэвэр гээд төрийн тэтгэлэгтэй андуурч болох ойролцоо нэр оноочихсон байдаг юм.

-Манай хөгшчүүд чинь тэгэхээр төрийн төсвийн мөнгийг зүгээр аваад идэж суугаа амьтад биш тэнхлүүн царигтай явсан цагтаа нэргүй дансанд өөрсдийнхөө хураасан хэдэн бор юмыг авч байгаа юм шив дээ. Тэгвэл тэтгэмж гэдэг нь?

-Тэтгэмж гэдэг бол үнэхээр л төрөөс өгч байгаа мөнгө шүү дээ. Эрхтэн согогтой хүмүүсийн, тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, олон хүүхэдтэйн гэх зэрэг тэтгэмжийг санхүүжүүлэх эх үүсвэр нь татвар төлөгчдийн мөнгөөр бүрддэг улсын төсөв гэж ойлговол зөв болно.

- Ойлгомжтой боллоо. Ингэхлээр 90-ээд оноос өмнөх тэтгэвэр гэж яриад байгаа мөнгө маань ажиллаж байх үедээ бүтээгээд цалиндаа авалгүй төрийн санд үлдээсэн мөнгөнөөс сар бүрд төрөөс тогтоосон хэмжээгээр авдаг сулын цалин гэж ойлгож байна. Би зөв ойлгож байна уу?

-Ерөнхийдөө зөв байна. Тэтгэвэр гэдэг нь өөрийн бүтээснээс төрд зээлдүүлэн хадгалуулаад дараа нь цувруулан авдаг хувийн мөнгө, тэтгэмж гэдэг нь төрийн төсвөөс авдаг татварын орлогын мөнгө. Тэтгэвэр, тэтгэмж хоёр нэг савнаас гардаггүйг ялгаж ухаарах нь чухал аа.

Татварыг аж ахуйн нэгжүүд төлдөг юм шиг харагддаг боловч үнэн хэрэг дээрээ хэрэглэгчдийн халааснаас төлдгийг, тэтгэвэр тэтгэмж хоёр сан хоёулаа улсын төсөв гэсэн нэг эх үүсвэрээс гардаг юм шиг санагддаг боловч тэтгэмж нь төсвөөс, тэтгэвэр нь урьдчилан хуримтлуулсан өөрийн сангаас гардгийг энэ хийсвэр зохиомжоор илэрхийлэх гэж оролдов оо.

Сэтгүүлч таны мэдлэгийн санд: "Глоб Интернэшнл" ТББ-ын номын сангийн дараах номыг санал болгож байна.



Ч.Базар.

Хэрхэн эрэн сурвалжлага хийх вэ

Ардчилал хөгжсөн оронд эрэн сурвалжлах сэтгүүл зүй ямар их үүрэгтэй, нийгэмд эрүүлжүүлэх үүрэг гүйцэтгэж байдгийг хэд хэдэн улс орны сэтгүүл зүйн практик дахь жишээ баримтаар нээн харуулж, Монгол дахь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч цаашдын төлөв байдлыг шинжин тодорхойлохыг зорьсон байна.



Иргэдэд зориулсан гарын авлага

Иргэд төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрх, уг эрхээ хэрэгжүүлэх арга замын талаархи мэдээллийг хялбар бөгөөд сонирхолтой хэлбэрээр хүргэсэн энэхүү гарын авлагад Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Үндсэн хууль, иргэдийн мэдээлэл олох эрхийг зохицуулсан бусад хууль эрх зүйн актуудыг багтаан оруулсан байна.

Сэтгүүлч ба хууль

СЭТГҮҮЛЧ ТА ТЭТГЭВЭР АВАХ УУ?

Та гарчгийг уншаад нэгийг эргэцүүлээ биз ээ.

Сэтгүүлч бид өдөр тутмын ажил гэсээр хувийн амьдрал, хойшид авах тэтгэвэр тэтгэмжийн асуудлаа тэр бүр боддог билүү. Ер нь гэрээ гэдэг тухайн талууд харилцан үүрэг хүлээхээр тохиролцсон тохиролцоо байдаг. Бид ажилд орохдоо ийнхүү эрх тэгш тохиролцоо хийж чаддаг билүү.....

Сэтгүүлч та өөрийн харьяалагдан ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагатай ямар гэрээнд үндэслэн ажилладаг вэ? Аман гэрээ, эсвэл хэлбэрийн төдий байгуулсан гэрээ юу?

Хөдөлмөрийн хуулинд зааснаар байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулах үүрэг ажил олгогчид оногддог бөгөөд хэрвээ өөр гэрээгээр ажиллуулж байгаа бол энэ нь хууль бус үйлдэл гэж та ойлгож болно. Хэрвээ тантай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй болон таныг хөдөлмөрийн гэрээ байгуулахыг шаардсаар байхад ажил олгогч биелүүлэхгүй бол та шүүхэд хандаж асуудлаа шийдвэрлүүлэх эрхтэй юм. Гэхдээ хамгийн гол нь таны ажлын байр байнгын ажлын байр мөн эсэхээс хамаарах учиртай. Байнгын ажлын байр гэдэг нь таны ажиллаж байгаа байгууллагын бүтцэд ордог батлагдсан орон тооны дагуу ажилтан авч ажиллуулж байгаа албан тушаал, ажлын байр юм.

Хөдөлмөрийн гэрээ бол нэг талаас ажилтан гэрээгээр тохирсон ажил үүргийн хуваарийн дагуу ажил олгогчийн заасан ажлын байранд хөдөлмөр эрхлэх, нөгөө талаас ажил олгогч нь ажиллаж хөдөлмөрлөх ая тухтай нөхцөлөөр хангах, тухайн ажил, албан тушаалд тохирсон цалин хөлс олгох үүргийг тус тус хүлээсэн тохиролцоо юм.

Хөдөлмөрийн гэрээ байгуулсны ач холбогдол нийгмийн даатгалтай салшгүй холбоотой. Нийгмийн даатгалын тухай хуулинд зааснаар нийгмийн даатгал нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй бөгөөд хөдөлмөрийн гэрээгээр ажиллахад нийгмийн даатгалд заавал даатгуулах хэлбэр үйлчилдэг. Улмаар таны нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг та өөрөө, тодорхой хувийг ажил олгогч төлөх үүрэгтэй байдаг

Даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар /	
	ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос
1/ тэтгэврийн даатгал	13,5	5,5
2/ тэтгэмжийн даатгал	1,0	1,0
3/ үйлдвэрлэлийн ооол, мэргэжлээс шалтгаалсан өгчний даатгал	1,0, 0,2 ба 3,0	-
4/ ажилчидийн даатгал	0,5	0,5
5/ эрүүл мэндийн даатгал	3,0	3,0
Нийт	19-22	10

1960 оны 1 сарын 1-нээс хойш төрсөн хүмүүсийн хувьд 1999 оны 7 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байгаа тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль үйлчилнэ. Энэ хуулиар тэтгэвэр тогтоолгох үед таны авах тэтгэвэр таны нэрийн дансандаа хуримтлуулсан нийт хуримтлалын хэмжээнээс шууд хамааралтайгаар бодогдоно. Таны нэрийн дансны хуримтлал дараах орлогоос бүрдэнэ. Үүнд нэрийн дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, ажил олгогчийн төлсөн шимтгэл, төрөөс төлсөн шимтгэл, нэрийн дансны орлогод тооцсон хүү, эдгээрээс бүрдэнэ. Тэтгэврийг олгоходоо нэрийн дансан дахь нийт хуримтлалыг тэтгэвэр авах дундаж хугацаанд хуваагаад, гарсан хариуг 12 сардаа хувааж таны 1 сард авах тэтгэврийг тогтоох учираас таны дансны хуримтлалаас ирээдүйн тэтгэвэр шууд хамааралтайг сайн бодолцох хэрэгтэй юм.

Та хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа ажил олгогчтой ажлын байрны буюу албан тушаалын нэр, гүйцэтгэх ажил үүрэг, үндсэн цалингийн буюу албан тушаалын цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг заавал тохиролцож гэрээндээ тусгасан байвал зохино. Хэрвээ та дээрх зүйлсийг тохирч гэрээндээ тусгуулаагүй бол таны эрх зөрчигдсэн тохиолдолд эрхээ

хамгаалах боломжгүй хүнд байдалд орно. Жишээ нь ажил олгогчийн санаачлагаар үндэслэлгүйгээр хууль бусаар ажлаас халсан тохиолдолд та шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах, өөрөөр хэлбэл буцаж хуучин ажилдаа орох, ажилгүй байсан хугацааны цалингаа нөхөж авах зэрэг эрхтэй. Гэвч та хөдөлмөрийн гэрээндээ цалингийн хэмжээгээ тохироогүй бол шүүхээс таны авах ёстой байсан цалинг нөхөж олгох шийдвэр гаргах боломжгүй юм.

Хөдөлмөрийн гэрээнээс өөр гэрээ буюу ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ зэргээр ажиллахад нийгмийн даатгалд та сайн дураар даатгуулах шаардлага гарна. Өөрөөр хэлбэл захиалагч талд таны төлөө нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг үүсэхгүй зөвхөн танд гэрээгээр тохирсон хөлсөө төлөх учраас тэр хэмжээгээр бага хуримтлалтай байна.

Хуульч Г.Даваахүү

Олон нийтийн мэдэх эх мэдээллийн эрх чөлөө /Хууль бөлвөрсруулагч, тогтоогчдод зориулсан гарын авлага/



"Глоб Интернэшнл" ТББ-аас эрхлэн гаргасан Сэтгүүлч ба хууль 5 цуврал номыг т олилуулж байна.

1. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө 2001 он
2. Ардчилсан сонгууль, хэвлэл мэдээлэл 2001 он
3. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө 2001 он
4. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг 2002 он
5. Нэр төр, гүтгэлэг 2002 он

Эмэгтэй сэтгүүлчид, эмэгтэйчүүд хүүхдийн эрхийн тухай "Глоб интернэшнл" ТББ-аас эрхлэн гаргасан Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага



Нэр төр, гүтгэлэг ба хэвлэл мэдээлэл

Олон улсын эрх зүйд ардчилсан нийгэмд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хувь хүний хууль ёсны нэр хүндийг хамгаалах үүднээс хязгаарлаж болохыг зөвшөөрсөн ч ийнхүү хязгаарлаж байгаа зорилго нь жинхэнэ ёсоор хүний нэр хүндийг хамгаалахад чиглэгдсэн, үр дүнтэй байх ёстой гэж үздэг.

Иргэний хуулийн гүтгэлгийн тухай заалтаас урган гардаг нэг асуудал нь гүтгэлгийн хэрэг үүсгэх бололцоог төрийн байгууллагуудад олгосон. Хувь хүн, хуулийн этгээд гүтгэлгийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхтэй ч энэ нь төрийн байгууллагад хамаарах ёсгүй гэж 19-р зүйл байгууллагаас үздэг. Олон орны дээд шүүх, сонгогдсон байгууллага, улсын эзэмшлийн компаниуд, улс төрийн нам гэх мэт төрийн байгууллагаас гүтгэлгийн талаар нэхэмжлэл гаргахыг шууд хориглодог байна. Энэ нь ардчилсан нийгэмд Засгийн газар, төрийн байгууллагыг чөлөөтэй шүүмжлэх боломжтой байх нь чухал болох, эдгээр байгууллагын нэр төр, алдар хүнд хэмжээтэй бөгөөд олон нийтээс хамааралтай болох, энэ шүүмжлэлд төрийн байгууллага ямар өргөн хүрээнд хариу өгч болохыг харуулж байна.

Мэдээлэл тараах нь зохистой байсан эсэхийг тодорхойлохын тулд нийтийн санаа зовоосон асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хир зэрэг чухал болох болон мэдээллийг хугацаа алдалгүй хүлээж авахын ач холбогдлыг тохиолдол тус бүрт шүүхээс харгалзан үзэх ёстой.

Хэн нэгний нэр төрд хууль бусаар халдсанаас үүсэх хор уршиг нь мөн чанарын хувьд тухайн хүн рүүгээ шууд чиглэсэн, хувийн шинжтэй байдаг.

2002 оны 9 сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчилж буй шинэ Эрүүгийн хуульд бидний судлан үзсэнээр хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчидтэй холбоотой гэж үзэж болохоор 18 зүйл заалт орсоны 17 нь хориглосон хэм хэмжээ тогтоосон ба нэг нь сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх нь гэмт хэрэг гэж сэтгүүлчийн эрхийг баталгаажуулсан заалт тус тус оржээ.

Эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлд гүтгэлгийн тухай заалтыг оруулсан байна. Эдгээр зүйлд бусдыг доромжлох болон бусдын талаар худал мэдээлэл түгээхийг гэмт хэрэгт тооцохоор заасан. Мөн хуульд шүүгч, прокурор, гаалийн болон татварын байцаагчийг оролцуулан төрийн албан хаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан доромжилсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ. Гэтэл дэлхийн улс орнууд гүтгэлгийн эсрэг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс татгалзаж, иргэний хууль тогтоомжоор зохицуулдаг байна.

2000 оны 12-р сарын 1-нд НҮБ-аас нэгэн Тунхаглал гаргасан бөгөөд түүнд “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, санаа бодлын асуудал дэлхийн олон оронд хямралт байдалд ороод байна. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх явцад нь сэтгүүлчид болон бусад хүмүүсийг дайран давшлах (цензурдэх), гүтгэлэг, доромжлолын хатуу хуулиар хохироох зэрэг хоёр хэлбэрийн түгшүүрээр илэрч байна” хэмээн дурьдаад “Гишүүн орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлах байдлыг хангахын тулд гүтгэлгийн эсрэг хуулиа эргэн нягталж, үүнийгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэхийг” уриалсан байдаг.

“19-р зүйл байгууллага”-аас гаргасан “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба гүтгэлгийн эсрэг хуулийн зарчим” гэсэн баримт бичигт дурьдснаар маргаантай, зөрчилтэй үйл явдал, юмс үзэгдлийн талаар мэдээлэхдээ болсон үйл явдал, бодит баримтыг бодитойгоор, мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах, нийтэлж нэвтрүүлсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, нөгөө талаар

мэргэжлийн үйл ажиллагаа юм. Нэгэнт үүрэг, хариуцлага хүлээж байгаа учраас тэр хэмжээгээр эрх буюу боломж нь нээлттэй байх ёстой.

Олон улс оронд хэн нэгний нэр төрийг хамгаалах нь гол төлөв буюу бүхэлдээ хувь хүний ашиг сонирхол гэж үздэг. Гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж, хатуу чанга шийтгэл ногдуулах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй хэрэг юм. Эрүүгийн хуулийн ийм заалтыг эрх мэдэл бүхий албан тушаалтнууд иргэдийн шүүмжлэлийг хязгаарлах, олон нийтийн хэлэлцүүлгийг зогсоохын тулд буруугаар хэрэглэдэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангадаг орнуудад ч үүнийг буруугаар хэрэглэх магадлал их байдаг байна. Шинэ эрүүгийн хуульд зааснаар гүтгэлгийн хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан бол гэж оруулсан нь ч хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх гол индэр болсон хэвлэл мэдээллийн хэрэгслийн эсрэг заалт болж байгаа юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үзэл бодлын чөлөөт индэр болохын хувьд нийгэмд бугшиж буй аливаа бусармаг явдлыг илчлэн олны сонорт хүргэж нийгэмд шүүмжлэлт, эрүүл саруул уур амьсгалыг бий болгохын төлөө тэмцдэг. Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээллийг нийтлэхээс эхлэн шүүхэд өөрийгөө хамгаалах зэрэг аливаа асуудалд нухацтай хандах, хуульд нийцүүлэх шаардлага гарч ирж байгаа юм.

Эндээс дүгнэхэд Монголын ардчиллын үйл явцад сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхний оруулсан хувь нэмэр их. УИХ-аас 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлан гаргасан нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан чухал үйл явдал болсон төдийгүй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг сайжруулахад ач холбогдолтой болсон юм. Гэсэн хэдий ч зарим харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт өнөөг хүртэл байхгүй, зарим хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, ялангуяа эрүү, иргэний хууль дахь холбогдох заалтууд нь хэт өргөн хүрээг хамарсан, хатуу чанга хариуцлагын тогтолцоог бүрдүүлээд байгаа юм.

Иймд Монгол улсад үзэл бодлоо илэрхийлэх ба мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан хуулиудыг олон улсын эрх зүйд нийцүүлэх, энэхүү тулгуур эрхийг бүрэн хүндэтгэх явдлыг хангахын тулд өргөн хүрээтэй арга хэмжээ авах шаардлагатай байна.

“Хадны мангас”-аас айсан айдас болон хувирсан хуулийн хатуу чанга заалтуудыг олон улсын жишигэд нийцүүлэн өөрчлөх, мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах, нөгөө талаар нууцын хүрээ хязгаарыг хумиж өгөх, хоорондоо зөрчилдөөнтэй хуулийн заалтууд, ялангуяа шинээр батлагдан гарсан хуультайгаа бусад хуулиа нийцүүлэх, системчлэх ажлыг цаг алдалгүй хийж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажиллах таатай таатай орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа юм.

Д.Мөнхбүрэн

(Footnotes)

- 1 Төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрхийн төлөв байдлын судалгаанаас, 2003 он
- 2 Шийдвэр 1998/48, 1998.04.17, параграф 2

Ронан Бради
Мэдээллийн эх сурвалжаа
хамгаалах нь

Европын сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөний
бүлгүүдэд зориулсан гарын авлага

Үнэнд итгэх нь

Дэлхий даяар сэтгүүлчид өөрсдөд нь нууц байдлаар мэдээлэл өгдөг хүмүүсийг хамгаалахыг эрмэлздэг. Ингэхдээ бид өөртөө онцгой эрх, статус эрдэггүй. Бид үүнийг бидэнтэй, олон нийттэй, бидний нөхөдтэй ярилцсаныхаа төлөө ноцтой үр дагавар бүхий эрсдэлтэй тулгарч буй тэр мэдээлэгчийн өмнө хүлээсэн үүрэг гэж үздэг. Ингэхгүй бол тэр мэдээлэл нууц болж, ямагт мэдээлэл хүсдэг олон нийтийн хэрэгцээг бид хангаж чадахаа болино. Хэрэв нэг л мэдээлэгчийн нууц байдал алдагдвал чухал мэдээлэлтэй өөр бусад хүмүүс сэтгүүлчдэд хандахыг хүсэхээ болино.

Эх сурвалж, мэдээлэгч, "шүгэлдэгч"-ийн хувьд энэ нь түүний эрх гэдэг нь ойлгомжтой. Үүний анхны шалгуур нь энэ эрхийг нийгэм, хууль хэрхэн хүлээн зөвшөөрснөөр хэмжигдэнэ. Тэгвэл сэтгүүлч эх сурвалжаа хамгаалах талаар юу хийвэл зохистой тухай ярилцъя.

Мэдээлэгчийн нууцыг хадгалах амлалт нь бүхий л нөхцөл байдалд жинтэй, цогц хэрэг мөн. Үүнийг бусад эрх үүрэг, хуулиас гадуур, тусгай авч үзэх ёсгүй. Сэтгүүлчид шүүхийн өмнө эх сурвалжаа илрүүлэхээс татгалзвал шүүх хурлын үр дүнд нөлөөлнө. Шүүхийн өмнө өөрийн үнэнч шударгыг харуулах нь иргэн бүрийн үүрэг. Зохих ёсны бүхий л нотолгоог шалгаж нягтлах нь шүүгчийн зөв төдийгүй төгс үйлдэл.

Энэ бүхний эсрэг олон нийтийн санаа зориг байх ёстой. Сэтгүүл зүй бол буруу үйлдлийг илрүүлэхэд зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч сэтгүүлч шүүх шаардсан тоолонгоор мэдээлэгчээ илчлээд байвал энэ үүрэг ч бас сүрхий хязгаарлагдах болно оо доо? Үнэ цэнэ бүхий мэдээлэл дарагдмал хэвээр үлдэхгүй гэж үү? Хэрэв бүх мэдээлэгчийг ажлаасаа халагдах, эсвэл аливаа байдлаар хохирч болзошгүйг мэдсээр байж, албан хүчээр нийтэд ил болгосноор авилгын асуудал, мөрдөн шалгагдах ёстой зүйлс яах вэ?

Энэ бол эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тулгуур асуудал юм. Уг хэрэг хүнд байхын хэрээр тухайн мэдээллийг дамжуулах нь мэдээлэгчид хүндрэлтэй байдаг. Хэвлэл мэдээлэл тийм ч ноцтой бус хэргийн талаарх нууц мэдээллийн урсгалаас хамаарч байдаг. Сурвалжлагч, мэдээлэгчийн хоорондын харилцааны чанар олон нийтийн анхааралд очих ёстой тэр мэдээллийн тоог шийдвэрлэдэг билээ. Эдгээр харилцааг үгүйсгэх нь бүхэл бүтэн тогтолцоо амаа хамхихад хүргэнэ.

Үүнээс болж зөвхөн олон нийт бага мэдээлэлтэй болоод зогсохгүй мэдээлэл найдвар муутай болно. Мэдээлэгч сэтгүүлчдэд хандсан ч гэсэн сэтгүүлч итгэлтэй хэлжээ холбоогоо ашиглаж чадахгүй. Учир нь сэтгүүлч ч бас өөрийг нь илчлэхээс айж, эх сурвалжийг шалгахад хэцүү болох бөгөөд аль хэр жинтэй мэдээлэл болохыг дүгнэхэд хүндрэл учирч, тэр бүү хэл түүнийг нотлох аргагүй болно.

Сонины томоохон хөрөнгөтнүүд сэтгүүл зүйн "мэдээ"-г олон янзаар тодорхойлсон байдаг. Лорд Нордкилиффе, Уильям Радольф нарын алдартай тодорхойлолтоор "мэдээ гэж хэн нэгэн хүн, хэзээ нэгэн цагт дарагдуулахыг хүсдэг зүйл" юм. Мэдээж аливаа таагүй баримт сэлтийг байгууллагууд олон нийтэд ил болгохыг хүсдэггүй. Сэтгүүлчид л тэдгээр баримт мэдээг мэдээлэхийн тулд байгууллагын

эсрэг хүч хөдөлмөрөө шавхах хэрэгтэй болно. Эх сурвалжийг боловсруулж байж л сэтгүүлч санасандаа хүрэх боломжтой.

Сэтгүүлчдийг шүүхийн тогтолцооны нэг хэсэг мэт ажиллахыг албадаж, нууцаа задлахыг, эсвэл тэднээс бичиг баримт, дүрс бичлэг зэрэг бусад хэлбэрийн нотолгоо шаардаж эхлэл тэд байгууллагаас хараат бус байж үл чадна. Энэ нь тэдэнд ноцтой аюул учруулна. Сэтгэл ханамжтай бус мэдээлэгчид сэтгүүлчдийн эсрэг гомдол мэдүүлдгийг бид мэднэ. Олон нийт ч мөн үүнээс болж хохирно. Зарим мэдээлэгч тухайн сэтгүүлчийг үнэхээр хараат бус гэдгийг мэдсэн тохиолдолд л мэдээллийг задруулна.

Гүүдвиний хэрэг

Британий эдийн засгийн сэтгүүлч Билл Гүүдвин 1989 онд Тетра компанианхүүгийн бэрхшээлтэй тулгарсан тухай эх сурвалжаас сонсчээ. Мэдээллийг байгууллагын нууц төлөвлөгөөнөөс авсан байв. Сэтгүүлч үүнийг баталгаажуулахын тулд Тетра компани руу утастахад компанийхан түүнийг эх сурвалжаа илчлэхийг албадахаар хөөцөлдөж эхэлжээ. 1981 оны Шүүхийг үл хүндэтгэх тухай актын дагуу Дээд Шүүх шударга ёсны эрх ашгийн төлөө гэсэн үндэслэлээр Гүүдвинийг Тетрагийн тухай тэмдэглэлээ ил болгох тогтоол гаргасан байна. Тэр татгалзав. Давж заалдсаны дараа түүнийг тэмдэглэлээ Тетрад өгөх, эсвэл лацадсан дугтуйд хийж, шүүхэд хүргүүлэх тогтоол гаргасан байна. Тэрээр дахин татгалзав. Хэрэг Британий дээд шүүх болох Лордуудын Танхимд очиход тэд өмнөх шатны шүүхийн шийдвэрийг дэмжсэн. Түүнийг дахин татгалзахад шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэн 5000 фунт стриленгээр торгожээ.

Гүүдвин Сэтгүүлчдийн Үндэсний Холбооны тусламжтайгаар Европыншүүхэд хандан даван заалдсан юм. 1996 оны 3 сард Страсбургийн шүүхээс эх сурвалжаа илчлэхийг албадсан тогтоол болон 5000 фунт стриленгийн торгууль нь 10-р зүйлийг зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасан билээ. Хүний Эрхийн Шүүх Их Британий шүүгчдийг "асуудалд өрөөсгөл хандсан" гээд "хязгаарлалтыг ардчилсан нийгмийн зайлшгүй шаардлага" гэж авч үзэж болохгүй гэсэн юм. Хүний Эрхийн Шүүх доорхи зүйлийг онцлон дурьдсан байна.

"Ийм хамгаалалтгүйгээр эх сурвалж олон нийтийн ашиг сонирхол бүхий хэргийн талаар олон нийтэд мэдээлэхэд нь сэтгүүлчдэд туслахаа болих магадлалтай. Үүний дүнд хэвлэл мэдээллийн нийгмийн хоточ нохой байх зайлшгүй үүрэг хөсөрдөж, тэдний нягт нямбай, найдвартай мэдээлэлээр хангах чадварт таагүй нөлөө үзүүлэх болно.

Ардчилсан нийгэм дэх хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөө сэтгүүлчийн эх сурвалжаа хамгаалахын ач холбогдлын үүднээс авч үзвэл эх сурвалжийг илчлэх нь тэрхүү эрх чөлөөг хэрэгжүүлэхэд туйлын хүйтэн цэвдэг хандаж буй хэрэг бөгөөд энэ нь олон нийтийн ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх шаардлагыг давж гарах үндэслэлгүй бол Конвенцийн 10-р зүйлтэй нийцэхгүй.

Энэ хэрэг сэтгүүлчдэд эх сурвалж хамгаалахад туйлын их дэмжлэг болсон. Гэсэн хэдий ч шүүх сэтгүүлчдийн эх сурвалжийн үнэмлэхүй хамгаалалтын дутагдалтай байдлыг тэмдэглэсэн байна. "Олон нийтийн ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх шаардлагыг давж гарах үндэслэлтэй" бол мэдээллийг илчлэх тогтоол гаргахыг зөвшөөрсөн нь шүүгчдэд "сүүлнээс хазах" боломж олгожээ.

"Глоб интернэшнл"ТББ-аас эрхлэн гаргасан "Эх сурвалжаа хамгаалах нь" номыг та манай номын сангаас авч уншиж болно.



Ажил хийхгүй амьдрах аминч шунахай сэтгэлгээнд ард түмэн идэгдвэл нийгэм доройтож, төр хямарч, авилгал улс төрд хүрээгээ тэлж, хууль цааз, хэвлэл мэдээлэл, бизнес, үйлчилгээний хүрээг ч хамардаг аюултай. Энэхүү эмхэтгэлээс та авилгалаас ангижрах арга замын талаар олон хүмүүсийн ухаанаа уралдуулан бичсэн нийтлэлийг унших болно



Хууль тогтоогчид хэвлэл мэдээллийн ажилтан, судлаачдад зориулан олон нийтийн өргөн нэвтрүүлгийн олон улсын жишиг загвар хуулиудыг энэхүү товхимолд багтаасан юм. Мөн сүүлийн жилүүдэд боловсруулсан зарим хуулийн төсөлд хийсэн гадаадын шинжээчдийн зөвлөмжтэй танилцаж болно.

Амьдралын үйлдвэрлэлд үүсэх нь өөрсө ахуйн аргаар нь үйлдвэрлэлд үүсэх



Осман Хусейн

Багаар ажиллаж байж дайны тухай мэдээ бичнэ. Дайны талбараас мэдээ бичихэд тухайн багийн хүн бүр эр зориг, хүчин чармайлт гаргах нь чухал. Энэ аюултай нөхцөлд мэдээ, сурвалжлага хийхэд Хуссейн Осман зэрэг хүн ихээхэн хувь нэмэр оруулдаг юм. Ай-Ти-Эн мэдээллийн агентлагт

орчуулагч, жолоочоор ажиллаж байсан тэрбээр 2003 оны гуравдугаар сарын 22-нд сураггүй болсон байна.

Хуссейн сэтгүүлч нөхдийнхөө хамт Иракийн өмнөд хэсгийн Басра хот хүрэх замдаа НҮБ болон Иракийн цэргүүдийн галын шугамд өртжээ. Энэ үеэр Хуссейн Ай-Ти-Эн мэдээллийн агентлагийн багийнхантай ажиллаад сар орчим болж байсан юм.

Энэ буудалцааны үеэр Ай-Ти-Ви мэдээллийн агентлагийн сурвалжлагч Терри Ллойд амь үрэгдсэн бөгөөд Ай-Ти-Эн-ийн зураглаач Фред Нерак болон Хуссейний хувь заяа хэрхэсэн нь тодорхойгүй байна. Тэр эмгэнэлт өдрөөс хойш энэ хоёр хүн сураггүй болжээ.

Гэр бүлийнхнийх нь ярьж байгаагаар Хуссейн хоёр хүүхдээ нялхад нь шөнө дөлөөр босч, угжиж, хуурайлахаас огт төвөгшөөдөггүй, тэдэндээ их хайртай сайн эцэг байсан гэнэ.

Тэрээр амьдралд хайртай, бусад залуучуудын адилаар хөл бөмбөг, усан сэлэлт, мөсөн гулгалтын спорт сонирхдог байсан. Түүний үүргээ ухамсарласан байдал, гадаад хэлэнд сонирхолтой, ялангуяа Англи хэл сайн эзэмшсэн зэрэг нь Ай-Ти-Эн агентлагийн багийн гол гишүүн болоход нөлөөлжээ. Буудалцаанаас амьд гарсан Ай-Ти-Эн –ийн багийн гишүүн Даниэль Демостиер Хуссейний дурсгалыг хүндэтгэн хэлсэн үгэндээ: “Тэрээр итгэхийн аргагүй хөдөлгөөнтэй хүн байсан. Иракт очихын өмнө бид ар талын бэлтгэлийг хангах асар их ажилтай байлаа. Хоол хүнс, ундны усаа базаах, майхан барих, цахилгаан үүсгүүр, компьютер зэрэг тоног төхөөрөмжөө бэлтгэх зэрэг олон ажил амжуулах ёстой байсан. Харин Хуссейн ямар ч үед юуг ч олж чаддаг болохоо энэ үеэр харуулсан. Түүнд Кувейтэд мэдэхгүй газар байхгүй мэт санагддаг байсан.”

Хуссейний хүн сайн таньдагийн ачаар Иракийн хилийн ойролцоох Кувейтийн хойд хэсгийн нэгэн аж ахуйд манай багийнхан Иракийн хил давахын өмнө хэд хоног байрласан юм.

Иракийн хил давсны дараа багийн гишүүд нэг шөнө цөлд хоноглох үеэр хиймэл дагуулаар ажилладаг тоног төхөөрөмжинд техникийн саатал гарсан юм. “Бид анхны зургаа авах гэж хэдэн цаг ноцолдсон боловч амжилт гараагүй” гэж Даниэль ярьсан байна. “Бид ямар их сэтгэлээр унасныг та төсөөлж байгаа биз дээ. Энэ хүнд үед Хуссейн бидний сэтгэл санаагаар дэмжиж, байнга инээмсэглэн, амттай цайгаар дайдж байсан. Залуучуудаа, сэтгэлээр битгий уна, та нар маргааш гэхэд Басрад очиж, амьдралдаа хамгийн шилдэг сурвалжлага хийнэ” гэж тэр бидэнд хэлж байсан. “Хуссейн эр зоригтой нэгэн төдийгүй хүнд үед хүн бүрт тусалдаг сайхан сэтгэлтэй хүн байсан” гэж Даниэль ярьжээ.

Аргентины чөлөөт сэтгүүлч, зураглаач Вероника Кабрера Иорданы Амман хотоос Багдад орохоос нэг хоногийн өмнө машины ослын улмаас гэмтэж, 2003 оны дөрөвдүгээр сарын 15-нд өөд болсон юм. Тэрээр Иракийн дайныг сурвалжилж яваад амь үрэгдсэн анхны эмэгтэй сэтгүүлч ажээ. Кабрера 29 настай гэр бүлтэй, гурван настай охинтой аж.

Тэрээр 60 гаруй сэтгүүлчийн хамт Багдадын зүг явж байсан юм. Түүний сууж явсан машин Багдадаас 120 км зайд Рамади хотод замаасаа хазайж хэд хэдэн удаа өнхөрч осолджээ. Си-Эн-Эн телевизийн сэтгүүлч Диего Бустос дөрөвдүгээр сарын 16-нд Вероникагийн нөхөр Омар Хернандесээс ярилцлага авчээ.

Вероникад ямар учраас дайны үйл явдлыг сурвалжлах сонирхол төрсөн гэж та бодож байна вэ?

А. Вероника дайны үйл явдлыг сурвалжилдаг сэтгүүлч болохыг мөрөөдөж байсан. Олон улсын ямар нэг мөргөлдөөн гарсан газар тэр яаж ийгээд очиж, мэргэжлийн дүн шинжилгээ хийхийг чармайдаг байсан бөгөөд дайны үйл явдлыг сайн сурвалжилдаг сэтгүүлч болох хүсэлтэй байсан.

Таны эхнэр дайны үйл явдлыг сурвалжлах гэж яваад өөрөөр хэлбэл хамгийн дуртай ажлаа хийж байгаад амиа алдсанд та бага ч болов тайвширдаг уу?

Дайн гэж юу болохыг өөрийн байр сууринаас дүрслэх эхнэрийнхээ хүслийг би хань ижлийнх нь хувьд ямагт дэмждэг байсан ч Вероника ийнхүү амиа алдсанд би хором ч тайвширч чадахгүй байна. Үнэндээ би гуьж гутарч ч чадахгүй байна. Одоо түүний цогцсыг эргүүлж авчрах ганцхан хүсэл байна.

Дайн, зэвсэгт мөргөлдөөний талаар олон мэдээ сурвалжлага хийж, хүнд бэрхийг даван туулсныхаа дараа Вероника ийнхүү авто ослоор өөд болсон нь их эмгэнэлтэй мэт санагдаж байна.

Тийм ээ, гэхдээ нөгөө талаас дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэж энэ осол гарсан шүү дээ. Шөнө зам хаахаас өмнө Багдад хүрэхийн тулд машины цуваа хамаг хурдаар давхиснаас осол гарсан байх.

Иракийн дайныг Вероника юу гэж дүгнэсэн бэ?

Ерөнхийдөө дайн бол ямар ч утгагүй зүйл хэмээн Вероника ямагт боддог байсан. Дайны үйл явдлыг сурвалжлах болсон нь түүний энэ үзэлтэй зөрчилдөж магадгүй л дээ. Энэ дайныг ч тэр ер нь бүх дайныг утгагүй зүйл хэмээн тэр үздэг байсан. Вероника ямагт дайнд хэлмэгдэгсэд, тэр дундаа хүүхдийн байр суурийг мэдээ сурвалжлагандаа тусгахыг чармайдаг байсан. Тэрээр дайны үеэр сураггүй болсон хүмүүс, дүрвэгсэд, хүүхэд гэх мэт дайнд хэлмэгдэгсэд бүх анхаарлаа тавин ажилладаг байсан. Зөвхөн энэ ч биш ер нь бүх дайн /тэрээр Афганистан, Косовогийн дайныг сурвалжилж байсан/ ямар ч хэрэггүй гэж тэр ярьдаг байсан юм.

Та эхнэртэйгээ хамгийн сүүлд хэзээ ярьсан бэ?

Түүнийгээ нас барахаас хоёр хоногийн өмнө ярьсан. Тэр маань Иракийн хилээр гарахын тулд гурван долоо хоногийн турш Иордани, Сирийн хилийн дагуу эргэлдсэн. Тэр Иракийн хилээр гарч чадаагүй учраас маш их бухимдаж байсан бөгөөд Палестинд



Вероника Кабрера

хэдэн зураг аваад гэртээ буцах бодолтой байгаагаа надад хамгийн сүүлд хэлсэн. Арваннэгэн цагийн алдад сэтгүүлчдийн энэ цуваанд нэгдэх боломж түүнд олдсон.....Энэ түүнийг үхэл рүү нь дуудаж байж л дээ.

Карберагийн нөхөр Омар Хернандес эхнэрийнхээ цогцсыг нутагтаа авчирч чадсан байна. Энэ аймшиг ослын дараагаар түүний цогцсыг БагдаддарааньКувейтэд, тэндээсАргентиндшилжүүлсэнбайна.

Орчуулсан Г.Нарангарав